

БАТЛАВ.

И.БАТХҮҮ

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ**  
**"Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх"**  
**төсөл / L3936-MON**

**АЖЛЫН ДААЛГАВАР**

**"ОЛОН-ЧБ" ХИЛИЙН УДИРДЛАГЫН НЭГДСЭН ТОГТОЛЦООНД ЗОРИУЛСАН**  
**ХЯНАЛТЫН ХЭРЭГСЛҮҮД**  
**ЗҮЧБЗАА / ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ**

## Товчлол

АХБ	–	Азийн хөгжлийн банк
АРИ	–	Хэрэглээний програмчлалын интерфэйс
БА	–	Барилгын ажил
БНХАУ	–	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БТ ХНУС	–	Багт туслах ХНУС
БЦ	–	Борлуулах цэг
ГА	–	Гүйцэтгэгч агентлаг
ГАМС	–	Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем
ГБМ	–	Гомдол барагдуулах механизм
ГЕГ	–	Монгол Улсын Гаалийн ерөнхий газар (ГЕГ)
ГИМНС	–	Гадаад иргэдийн мэдээллийн нэгдсэн систем
ГИХГ	–	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХЯ	–	Гадаад харилцааны яам
ЗДН (ЯЗХС)	–	Зорчигчийн дэвшилтэт нэвтрүүлэлт (Явах зорчигчийн хяналтын систем)
ЗИ	–	Зүйлсийн интернэт
ЗТБХ		Зургийг текст болгон хөрвүүлэгч (OCR)
ЗҮЛТ	–	Замын-Үүдийн Логистикийн төв
ЗҮЧБ	–	Замын-Үүдийн чөлөөт бүс
ЗҮЧББ	–	Замын-Үүд чөлөөт бүсийн боомт
ЗҮЧБЗАА	–	Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба
ЗҮЭХХДЭЗБ	–	Замын-Үүд – Эрээн хотын хил дамнасан эдийн засгийн бүс
МУБ	–	Машинаар унших бүс
МУЗГ	–	Монгол Улсын Засгийн газар
МУЦС	–	Монгол Улсын цагаачлалын систем (ХХЕГ, ГИХГ)
МУШС	–	Монгол Улсын Шадар сайд
МХЕГ	–	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХХТ	–	Мэдээллийн харилцаа холбоо, технологи
НАТХ	–	Нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгсэл
НБ	–	Нэвтрэх боомт
НШБ	–	Нүдээр шалгах бүс
ОСКХ	–	Оршин суугчийн карт хэвлэх
ОУСК	–	Олон улсын санхүүгийн корпорац
ӨС	–	Өгөгдлийн сан
СБС	–	Сургагч багшийн сургалт
СЯ	–	Сангийн яам
ТЗСАУ	–	Тусгай зөвшөөрлийн самбарын автомат уншигч
ТХН	-	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТХҮ	–	Төлбөртэй холбоотой үзүүлэлт
УБ	–	Улаанбаатар

УМС	–	Удирдлагын мэдээллийн систем
ҮАЗҮГ	–	Үйл ажиллагаа, засвар үйлчилгээний газар
ҮХГ	–	Үндэсний хөгжлийн газар
Х-ХББХС	–	Хөдөлгөөнт хилийн боомтын бүртгэл, хяналтын систем
ХА	–	Хэрэгжүүлэгч агентлаг
ХББХС	–	Хилийн боомтын бүртгэл, хяналтын систем (өмнөх нэршил БОРЕКС)
ХБГО	–	Хөгжиж буй гишүүн орон
ХЗДХЯ	–	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНУС	–	Хилийн нэгдсэн удирдлагын систем
ХНЦ	–	Хил нэвтрэх цэг
ХТ	–	Хэрэглэгчийн туршлага
ХҮАТ	–	Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө
ХҮСБНТ	–	Хилийн үйлчилгээ сайжруулах бүс нутгийн төсөл
ХХББ	–	Хөтөлбөр хэрэгжүүлэх баримт бичиг
ХХЕГ	–	Хил хамгаалах ерөнхий газар
ХХМТГ	–	Монголын харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ХХХУ	–	Хатуу хог хаягдлын удирдлага
ХХХУ	–	Хатуу хог хаягдлын удирдлага
ХЦУХЦ	–	Хорио цээр, ургамлын хорио цээр
ХШУС	–	Хяналт шалгалтын удирдлагын систем (МХЕГ)
ХШҮ	–	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХЭАУЭААХБНХШТ	–	Худалдааны эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг бүс нутгийн хэмжээнд шинэчлэх төсөл
ЦХХХЯ	–	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
ЧБ	–	Чөлөөт бүс
ЭЗХАБХ	–	Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх
ЭЗХАБХТ	–	Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл
ЭЗХЯ	–	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭЗЧБ	–	Эдийн засгийн чөлөөт бүс

## 1. ҮНДЭСЛЭЛ

Чөлөөт бүсүүдийг хөгжүүлэх нь Монгол Улсын үндэсний тэргүүлэх зорилт бөгөөд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д нийцсэн зорилт юм. Чөлөөт бүсэд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, худалдааг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэхээр төлөвлөж байна. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны (КАРЕК) хөтөлбөрийн 4b коридорын дагуух Замын-Үүд сум дах чөлөөт бүсийн (ЗҮЧБ) эдийн засгийн чадавх, стратегийн байр суурийг ашиглах шаардлагатай байна. КАРЕК-ийн коридорууд нь бүс нутгийн эдийн засгийн гол төвүүдийг холбож, далайд гарцгүй Монгол зэрэг КАРЕК-ийн орнуудыг Ази, Европ болон дэлхийн бусад зах зээлтэй холбодог.

Замын-Үүд нь Монгол Улсын тээврийн сүлжээний уулзвар, олон улсын гол боомтуудын нэг бөгөөд Тяньжин боомтоор далайд гарах хамгийн дөт зам болдог. Замын-Үүд сум нь 48.6 мянган га газар нутагтай бөгөөд үүний 70% нь улсын тусгай зориулалтын газар юм. “Замын-Үүд”-ийн чөлөөт бүсийг 2003 онд байгуулж, 2011 онд Ерөнхий төлөвлөгөөг нь баталсан.

АХБ нь 2020 оны 6 дугаар сард L3936-MON - Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх (51410-001) төслийг Монгол улсад хэрэгжүүлэхээр баталсан. Төсөл хэрэгжүүлэх гэрээг Монгол улсын засгийн газар ба Азийн хөгжлийн банк 2020 оны 7 дугаар сарын 2-нд байгуулсан. Энэхүү төсөл нь Монгол улсын эдийн засгийг төрөлжүүлэх, бүс нутгийн болон олон улсын үнэ цэнийн сүлжээнд нэгтгэх, хөдөлмөр эрхлэлт болон эдийн засгийн боломжийг бүрдүүлэх үйл явцыг хурдасгах юм. ЭЗХАБХ төсөл нь Замын-Үүд чөлөөт бүсийн эдийн засгийн болон хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг дараах замаар дэмжих болно, үүнд: (i) дэд бүтэц болон барилга байгууламж барьж, ашиглалтад оруулах; (ii) тогтвортой менежмент, үйл ажиллагааг дэмжих; болон (iii) чөлөөт бүсэд боомтын нэвтрэх системийг байгуулах тус тус болно.

Төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), гүйцэтгэгч байгууллагаар Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ), “Замын-Үүд” чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба (ЗҮЧБЗАА) тус тус хариуцан ажиллаж байна.

Хилийн удирдлагын нэгдсэн (ХУН) тогтолцоо нь худалдааг хөнгөвчлөх, нийгмийн аюулгүй байдал, хяналт шалгалтын өндөр түвшинг, тэр дундаа хил дамнасан эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтойгоос гадна хамгийн чухал нь хилийн аюулгүй байдлыг өндөр түвшинд хангахад чиглэнэ. Үүнд:

- (i) Зорчигч;
- (ii) Тээврийн хэрэгсэл;
- (iii) Бараа бүтээгдэхүүн.

ХУН тогтолцоо нь улсын болон олон улсын түвшинд хилийн менежментэд оролцож буй бүх оролцогчдын хамтын ажиллагаа, зохицуулалтыг шаардана. Хилийн боомт, хилийн боомт хоорондын харилцаа холбоо, мэдээлэл солилцоо, харилцан туслалцааг сайжруулснаар улсын хилийг илүү үр дүнтэй, үр ашигтай удирдах боломжтой болох юм. Үүнд:

- (i) Хуурай газрын ХНЦ (Хил нэвтрэх цэг)-үүд, далайн боомтууд, олон улсын нисэх онгоцны буудал дээр;
- (ii) Бүс нутгийн эсвэл үндсэн төв байранд;
- (iii) ЧБ (Чөлөөт бүс)-үүд;
- (iv) Хилийн шугамын дагуу: хуурай замын хил (ногоон хил), гол мөрөн, нуур цөөрөм, далайн хил (цэнхэр хил);
- (v) Хилийн ойр орчим (хилийн бүс).

ХУН тогтолцооны үзэл баримтлал нь модуль бүтэц бүхий гурван баганаас бүрдэнэ:

- (i) Үйл ажиллагааны дотоод хамтын ажиллагаа: үйлчилгээ, салбарын яам доторх;
- (ii) Оролцогч талууд хоорондын хамтын ажиллагаа: Өөр өөр яам, эсвэл хилийн хяналтын байгууллагуудын хооронд;
- (iii) Олон улсын хамтын ажиллагаа: бусад улс орон, олон улсын байгууллагуудтай.

## **2. БАЙРШИЛ**

Улаанбаатар хот, Монгол улс.

## **3. АЖЛЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэ ажлын гол зорилго нь улсын хэмжээнд хилийн удирдлагын нэгдсэн (ХУН) тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус ЧБ-д нэвтэрч байгаа хувь хүн, бараа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах зорилго бүхий вэбэд суурилсан “Олон-ЧБ” хяналтын самбарыг ЧБ-ийн удирдлагууд болон ЭЗХЯ-нд зориулан хөгжүүлэх юм.

Гаалийн ерөнхий газрын хариуцан ажиллуулдаг КАИС систем нь ЧБ-үүдэд орох/гарах бүх зорчигч, тээврийн хэрэгсэл болон барааны бүртгэл мэдээллийг цуглуулдаг. ГЕГ нь өгөгдөл солилцох API гаргаж өгнө. “Олон-ЧБ” хяналтын самбар нь КАИС системд API холболтоор бодит-цагт холбогдох ба эхний ээлжинд Замын-Үүд дэх чөлөөт бүсэд (ЗҮЧБЗАА) холболт хийгдэж ажиллана.

Бүх оролцогч талууд хоорондоо төрийн мэдээлэл солилцооны ХУР системийг ашиглан өгөгдөл дамжуулах ба бусад системүүд тухайлбал Гадаад худалдааны цахим нэг цонх зэргийг (FTSEW - Project ADB / RIBS) ашиглана.

“Олон-ЧБ” хяналтын самбарыг ГЕГ-н системийн өргөтгөл хийгдэж өгөгдөл солилцох API-ийн хөгжүүлэлт дууссаны дараа хийнэ.

“Олон-ЧБ” хяналтын самбарын концепц, техникийн даалгавар, онцлог шинж чанаруудыг боловсруулав. Зарим техникийн даалгавар, онцлог шинж чанаруудыг хөгжүүлэлтийн өмнө болон хөгжүүлэлтийн үеэр МТ компани, ЗҮЧБЗАА, ГЕГ болон ХУН тогтолцооны оролцогч талууд илүү нарийвчлан үнэлэх шаардлагатай. Ийм байдал нь аливаа мэдээллийн систем хөгжүүлэх ажлын нэг хэсэг байдаг. МТ-ийн компани гүйцэтгэл, тогтвортой байдал, аюулгүй байдал, хэм хэмжээ, менежментийн асуудлыг шийдвэрлэх санал, зөвлөмжийг ирүүлснээр төслийн гүйцэтгэлд илүү үнэ цэнийг нэмэх болно гэж үзэж байна.

“Agile” аргазүйг олон давхаргат төсөвтэй хослуулснаар анхны тодорхойлолт (зарим нэмэлт онцлог, зарим онцлогийн тодорхой бус байдал), шинэ өөрчлөлт болон нэмэлт хүсэлтийг хамруулах боломжоор хангагдана (Beta хувилбараас Хувилбар 1).

Системийн эх код нь ЗҮЧБЗАА-ны өмч болох ба хөгжүүлэлтийг нээлттэй эхийн технологид суурилан хийнэ. “Олон-ЧБ” хяналтын самбар нь эцсийн хэрэглэгчдэд өгөгдөл өөрчлөх боломжгүй (өгөгдөл оруулахгүй) мэдээллийн (жагсаалт болон дэлгэрэнгүй) агуулсан хяналтын самбар байна.

Хувилбар 1 баталгаажсанаас хойш 1-жилийн турш үүлэн хостод байршуулах ажил энд мөн орно.

### **3.1 Гарах үр дүн & Хүргүүлэх баримт бичиг**

Дараах нийт (4) дөрвөн дүнд хүрэх шаардлагатай:

- (i) **Нарийвчилсан дизайн:** Хөгжүүлэлт эхлэхээс өмнө МТ компани нь ГЕГ-ын томилсон албан тушаалтантай хамтран хэрэгцээний үнэлгээ хийж нарийвчилсан дизайн гаргана.
- (ii) **Бета хувилбар:** Мэдээллийн технологийн компани нь КАИС-ийг ХУН тогтолцоонд холбох өргөтгөлийн модуль боловсруулж, туршиж, хэрэгжүүлнэ. Бета хувилбараас Хувилбар 1 болгон шинэчлэх үед хэрэглэгчийн гарын авлага, туршилт, сургалт хийх;
- (iii) **Хувилбар 1:** Бета хувилбарыг Хувилбар 1 болгон шинэчлэх. ХУН тогтолцоо өргөтгөлийн модулийг ЗҮЧБЗАА, ГЕГ ба ЭЗХЯ-ны дүрэм журам, практикт тохируулахын тулд нарийвчилсан дизайн болон хөгжүүлэлтийн үе шатанд МТ компани нь бизнес процессуудад засвар, өөрчлөлт хийх.
- (iv) **Төслийн баримтжуулалт:** Төслийн болон техникийн баримт бичиг, хэрэглэгчийн гарын авлагуудыг англи, монгол хэл дээр боловсруулна.
- (v) **Систем хөгжүүлэлтийн бичиг баримт:** Систем хөгжүүлэлтийн бичиг баримтууд болох API бичиг баримт, Дэд бүтцийн нарийн диаграмм, эх кодыг тайлбарласан коммент, суурин болон серверийн орчинд системийг ажиллуулах дэлгэрэнгүй заавар, ашигласан технологийн хувилбарын мэдээллийг хүлээлгэн өгөх.

Ажлыг 2024 оны 8-р сард эхлүүлж, 6 сарын дотор дуусгах.

### **3.2 Дүрэм, журам, стандарт**

Мэдээллийн технологийн компанийг ЗҮЧБЗАА, ЭЗХЯ, Хандивлагч болон ТХН-тэй зөвшилцсөний үндсэн дээр шалгаруулж авна:

- (i) Үнийн санал харьцуулалтын арга (RFQ).
- (ii) Мэдээллийн технологийн компани нь бусад талтай хамтарсан консорциум эсвэл туслан гүйцэтгэгчийн гэрээ хийх байдлаар чадамжаа дээшлүүлэхгүй байх.
- (iii) Үзэл баримтлал, техникийн шаардлагууд болон санхүүгийн саналын загварыг хураангуй жагсаалтад орсон оролцогчдод хүргүүлнэ.
- (iv) Англи хэл нь төслийн бүх хугацаанд (компанийн бүртгэл гэх мэт баримт бичгээс бусад) худалдан авалт, харилцаа холбоо, баримт бичиг, тайлагнах албан ёсны хэл байна. Шаардлагатай баримт бичгүүдийн орчуулгыг Мэдээллийн технологийн компани хариуцна.
- (v) Мэдээллийн технологийн компани нь ажлын даалгаврын (АД/TOR) дагуу чанартай үр дүнг цаг тухайд нь хүргэх үүрэгтэй. Мэдээллийн технологийн дотоодын компани нь хүлээгдэж буй үр дүнд хүрэх, бүтээгдэхүүн болон харилцаа холбоог хангахын тулд төслийн явцад ЗҮЧБЗАА, ЭЗХЯ-ны томилсон ажилтнууд болон ТХН-ийн хяналт дор нягт хамтран ажиллана.
- (vi) ЗҮЧБЗАА, ЭЗХЯ болон ТХН нь төслийн бүх үе шатанд оролцож, мэдээллийн технологийн компанийн ажлын гүйцэтгэл ба үр дүнг тогтмол хянаж ажиллана

## **4. МТ КОМПАНИ, ГОЛ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЧАДВАР, ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

### **4.1 Ерөнхий шаардлага:**

МТ компани нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- (i) Монгол улсын Улаанбаатар хотод хуулийн хүрээнд оршин байдаг байх;
- (ii) Сүүлийн 3-аас доошгүй жил програм хангамж хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр бүртгүүлж, мэргэшсэн байх;

- (iii) Дараах төрлийн системийг хөгжүүлэх, нэгтгэх, хэрэгжүүлэх талаар батлагдсан туршлагатай байх. Үүнд:
  - a. Вэбд суурилсан систем хөгжүүлэлт, интеграци;
  - b. Олон байгууллага хоорондын өгөгдөл солилцоо (ж.н: API);
- (iv) Хамгийн багадаа 20,000 ам.долларын төсөвтэй удирдлагын мэдээллийн системийн хоёр төслийг амжилттай хэрэгжүүлсэн байх
- (v) Ажлын даалгаварт заасан чиглэлээр шаардлага хангасан мэргэжилтнүүдтэй байх.

#### **4.2 Багийн бүрэлдэхүүн, мэргэшлийн шаардлага, гол мэргэжилтнүүдийн ажлын даалгавар**

- (i) Мэдээллийн технологийн компани нь ажлын даалгаварт заасан даалгавруудыг гүйцэтгэх чадвартай багийг бүрдүүлж, санал болгоно.
- (ii) Мэдээллийн технологийн компани нь дэлхийн шилдэг туршлага, Монгол Улсын стандарт, АХБ-ны шаардлага, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг стандартуудын дагуу техникийн болон санхүүгийн санал болон бусад холбогдох баримт бичгээ бэлтгэнэ.

Мэдээллийн технологийн компани нь хамгийн багадаа дор дурдсан мэргэжилтнүүдтэй багийг ажиллуулна:

**Хүснэгт 1: Гол мэргэжилтнүүдийн ба тэдгээрийн оролцооны хураангуй**

№	Албан тушаал	Тоо ширхэг	Хүн-сар				Нийт Хүн-сар
			Бүрэлдэхүүн I	Бүрэлдэхүүн II	Бүрэлдэхүүн III	Бүрэлдэхүүн IV	
	<b>Гол мэргэжилтнүүд (дотоодын)</b>						
K-1	БА - Багийн ахлагч ба системийн ахлах хөгжүүлэгч (Мэргэжлийн инженер)	1	0.5	1.5	0.5	0.5	3.0
K-2	АХ - Системийн ахлах хөгжүүлэгч (Мэргэжлийн инженер)	1	0.0	2.5	0.5	0.0	3.0
	<b>Нийт гол мэргэжилтнүүд</b>	2	0.5	4.0	1.0	0.5	6
	<b>Гол бус мэргэжилтнүүд (дотоодын)</b>						
	<b>Нийт гол бус мэргэжилтнүүд (дотоодын)</b>	0	0				
	<b>Нийт</b>	2	0.5	4.0	1.0	0.5	6

БА = Багийн ахлагч, БАН = Бизнес аналит, АХ = Системийн ахлах хөгжүүлэгч, ААХ = Андройд ахлах хөгжүүлэгч, ЧБС = Чадавх бэхжүүлэгч/Сургагч, СТ = Системийн туршигч ба Чанар шалгагч.

Шаардлагатай гэж үзвэл Мэдээллийн технологийн компани нь гол бус мэргэжилтнүүд нэмж болно.



### 4.3 Нарийвчилсан мэргэшил

Хүснэгт 2 -д мэдээллийн технологийн компанийн багийн гишүүдийн мэргэшил болон гүйцэтгэх үүрэг/даалгавруудыг тусгасан болно.

### Хүснэгт 2: Багийн гишүүдийн мэргэшлийн нарийвчилсан шаардлага ба гүйцэтгэх үүрэг/даалгаврууд

No.	Албан тушаал	Хүн-сар	Шаардлага	Үүрэг/Даалгавар
<b>Гол мэргэжилтнүүд (дотоодын)</b>				
K-1	БА - Багийн ахлагч ба системийн ахлах хөгжүүлэгч	6	<ul style="list-style-type: none"> <li>(i) Мэдээллийн технологийн чиглэлийн Магистр зэрэгтэй</li> <li>(ii) Мэдээллийн технологийн чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай</li> <li>(iii) 5 болон түүнээс дээш жил онлайн мэдээллийн систем, API хөгжүүлэлт хийх төсөл удирдаж байсан туршлагатай</li> <li>(iv) Англи хэлтэй орчинд 3-аас доошгүй жил суралцаж эсвэл ажиллаж байсан туршлагатай. Англи хэлний өндөр түвшний ур чадвар (бичгийн болон аман) давуу тал болно</li> </ul>	<p>Үүрэг, хариуцлагууд (үүгээр хязгаарлагдахгүй):</p> <ul style="list-style-type: none"> <li>(i) Мэдээллийн технологийн компанийг төлөөлөх;</li> <li>(ii) Ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, баталгаажуулах, ТХН болон Захиалагчид тайлагнах үүрэгтэй. Багийн ахлагч нь зөвлөх багийг удирдаж, Үйлчлүүлэгч болон ТХН-тэй нягт хамтран ажиллана;</li> <li>(iii) Захиалагч болон ХУН тогтолцооны бусад оролцогч талуудтай хамтран системийн үнэлгээ хийх;</li> <li>(iv) Нарийвчилсан дизайныг боловсруулах;</li> <li>(v) Системийг хөгжүүлэх, турших;</li> <li>(vi) Support trial sessions;</li> <li>(vii) Ажлын төлөвлөгөө, хуваарь, төсөв, тайлангууд (эхлэлийн, сарын г.м), эцсийн тайлангуудыг боловсруулж, хянан шалгах ба багийн гишүүдийн бэлтгэсэн бусад тайланг захиалагч болон ТХН-тэй хамтран хянах ба Захиалагчаар батлуулах;</li> <li>(viii) Нарийвчилсан дизайн, хэрэгцээ шаардлага, мэдээлэл, өгөгдөл, хэрэглэгчид, бизнес процесс, үйлчилгээ болон тоног төхөөрөмжийн хэрэгцээний урьдчилсан үнэлгээ хийж төслийн багийг удирдан чиглүүлэх;</li> <li>(ix) Төслийн багийн ажлыг зохицуулж, гэрээний дагуу үзүүлж буй үйлчилгээний үр дүн, чанарыг хариуцах (Бета хувилбар, Туршилтын төсөл(үүд), сургалтууд, Хувилбар 1 гэх мэт);</li> <li>(x) Багийн гишүүдээр ажлыг нь цаг тухайд нь, нэгдмэл байдлаар гүйцэтгүүлэх.</li> </ul>
K-2	АХ - Системийн ахлах хөгжүүлэгч	6	<ul style="list-style-type: none"> <li>(i) Мэдээллийн технологийн чиглэлийн бакалавр зэрэгтэй</li> </ul>	<p>Үүрэг, хариуцлагууд (үүгээр хязгаарлагдахгүй):</p> <ul style="list-style-type: none"> <li>(i) БА болон БАН -ийн ерөнхий удирдамж дор ажиллах;</li> <li>(ii) Системийг хөгжүүлэх, турших;</li> </ul>

No.	Албан тушаал	Хүн-сар	Шаардлага	Үүрэг/Даалгавар
			<p>(ii) Мэдээллийн технологийн салбарт онлайн систем, API хөгжүүлэх чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай</p> <p>(iii) Системүүд хооронд өгөгдөл солилцох API хөгжүүлэлт хийж байсан туршлагатай</p>	<p>(iii) Бусад багийн гишүүд, Захиалагч, ТХН-тэй нягт хамтран ажиллаж, тайлан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;</p> <p>(iv) Туршилт, сургалт, хийх.</p>